# ОРХОН АЙМГИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ

ХЯНАСАН:
ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ,
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА М.ТҮМЭНЖАРГАЛ

2024 оны 06 дугаар сарын 14

АЙМГИЙН ЗДТГ-ИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ж.БААСАНСҮРЭН

2024 оны 06 дугаар сарын 14

ТАЙЛАГНАСАН:
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ, БИЕИЙН ТАМИР
СПОРТЫН ГАЗРЫН ДАРГА Д.ДЭЛГЭРБАЯР

2024 оны 06 дугаар сарын 07

## ОРХОН АЙМГИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

2024 оны 06 дугаар сарын 11-ний өдөр

Орхон аймаг

| д/д | Зорилт / Үнэлгээ | | Бүгд | Гүйцэтгэлийн зорилт 1 | Гүйцэтгэлийн зорилт 2 | Гүйцэтгэлийн зорилт 3 | Гүйцэтгэлийн зорилт 4 | Гүйцэтгэлийн зорилт 5 | Гүйцэтгэлийн зорилт 6 | Гүйцэтгэлийн зорилт 7 | Гүйцэтгэлийн зорилт 8 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Арга хэмжээний тоо | | 71 | 9 | 17 | 8 | 9 | 19 | 5 | 1 | 3 |
| 2. | 6.2.1 буюу 100% ба түүнээс дээш | | 35 | 4 | 11 | 4 | 5 | 7 | 2 | 1 | 1 |
| 3. | 6.2.2 үүнээс | 98.5% | 1 | | | 1 | | | | | |
| | | 95.0% | 2 | | 1 | | | | | | 1 |
| | | 92.3% | 1 | | | 1 | | | | | |
| | | 90.0% | 4 | 2 | | | | 1 | | | 1 |
| | | 85.7% | 1 | | | | 1 | | | | |
| | | 85.0% | 1 | 1 | | | | | | | |
| | | 76.6% | 1 | | | | | | 1 | | |
| | | 72.3% | 1 | | | | | 1 | | | |
| | | 70.0% | 9 | | 3 | | 2 | 3 | 1 | | |
| | | 50.0% | 7 | 2 | 1 | | | 4 | | | |
| | | 30.0% | 2 | | | | | 2 | | | |
| | | х/б-гүй | 6 | | 1 | 1 | 1 | 1 | 1 | | |
| Ерөнхий үнэлгээ, хувь | | | **90.1% буюу 4.5 оноо** | 85.0% буюу 4.25 оноо | 90.9% буюу 4.55 оноо | 98.5% буюу 4.92 оноо | 90.7% буюу 4.54 оноо | 74.0% буюу 3.7 оноо | 86.7% буюу 4.33 оноо | 100% буюу 5.0 оноо | 95.0% буюу 4.75 оноо |

ХЯНАСАН: АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА М.ТҮМЭНЖАРГАЛ

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН: ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ж.БААСАНСҮРЭН

## ОРХОН АЙМГИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ

2024 оны 06 дугаар сарын 10-ны өдөр

Баян-Өндөр сум

| д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Стратеги төлөвлөгөөний зорилт-1. Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл амьдралын зан төлөв насан туршийн дадал олгох зорилт бүхий биеийн тамирын хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх | Улсын төсөв 3,5 сая төгрөг, Орон нутгийн төсөв 134,9 сая төгрөг | Иргэдийн бие бялдрын хөгжлийн түвшин дээшилж, идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх орчин нөхцөл сайжирч биеийн тамирын үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн байх | Биеийн тамирын уралдаан тэмцээн, өдөрлөгийн арга хэмжээг 160 удаа зохион байгуулж 40,013 иргэний хамруулсан. | Биеийн тамирын уралдаан тэмцээн, өдөрлөгийн арга хэмжээ 165 удаа зохион байгуулж, 40,621 иргэнийг хамруулна, | Биеийн тамир, чийрэгжилтийн 79 удаагийн арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор 32,450 иргэн хамрагдлаа.<br>Хүн амын бие бялдрын түвшин тогтоох сорилд аймгийн хүн амын 12,3% буюу 13,181 хүнийг хамруулж үүнээс 53,7% нь А, В,С үнэлгээтэй дүгнэгдсэн.<br>Амралт, чөлөөт цагийн 5 талбайд дасгал хөдөлгөөн, тэмцээн уралдаанд 2800 иргэнийг тус тус хамруулж ажиллалаа. | 70%<br>85 |
| 1.1 | Арга хэмжээ-1:<br>Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил аван, дүн мэдээг программд нэгтгэн оруулж Биеийн тамир, спортын улсын хорооны Биеийн тамирын хэлтэст тайлагнана. | Улсын төсөв 500.0 мянган төгрөг | Сорилд хамрагдсан иргэдийн тоо | Сорилд 9,631 иргэнийг хамруулсан. | Сорилд 14,899 иргэнийг хамруулна. | Тайлант оны эхний хагас жилд хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилыг аймгийн иргэдийн дунд 3-5, 6-8, 9-12, 13-15, 16-18, 15-65 насны ангиллаар зохион байгуулж, нийт 13,181 иргэнийг хамруулж, мэдээллийг биеийн тамир, спортын улсын хорооны www.cpanel.sport.gov.mn сорилын цахим програмд шивж оруулсан. | 90%<br>100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.2 | Арга хэмжээ-2: Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд хамрагдсан иргэдийн түвшинг сайжруулж, үр дүнг Биеийн тамир, спортын улсын хорооны Биеийн тамирын хэлтэст тайлагнах; | Орон нутгийн төсөв 1,0 сая төгрөг | Сорилд хамрагдсан иргэдээс А, В, С үнэлгээтэй иргэдийн тоо | Сорилд хамруулсан иргэдээс А,В,С үнэлгээтэй иргэд 6804 буюу 70%-д хүргэсэн. | А, В, С үнэлгээтэй иргэдийн тоог 263 хүнээр нэмэгдүүлж, 7067-д хүргэнэ. | Аймгийн хүн амаас 13,181 иргэнийг бие бялдрын түвшин тогтоох сорилд хамруулсанаас 7082 иргэн буюу 53.7% нь А, В, С үнэлгээтэй байна. | 100% ✓ |
| 1.3 | Арга хэмжээ-3: Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилын төвийг фитнес клубыг түшиглэн байгуулах; | Орон нутгийн төсөв 120,0 сая төгрөг | Сорилын тоног төхөөрөмжийг худалдан авч, үйл ажиллагааг эхлүүлсэн байх | - | Фитнес клубыг түшиглэж сорилын төвийг байгуулна. | Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилын төвийг фитнес клубыг түшиглэн байгуулахаар 150м²-аас дээш талбайн шаардлага хангасан аймгийн Maksimus фитнес клуб, Wase фитнес клубуудын материалыг Биеийн тамир, спортын улсын хороонд хүргүүлсэн.Одоогоор улсын хорооноос хариу ирээгүй байна. | ~~30%~~ 50 |
| 1.4 | Арга хэмжээ-4: Биеийн тамир, спортын чиглэлд төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллага, спорт холбоодод шилжүүлэн хамтран ажиллах гэрээ байгуулж, дэмжлэг үзүүлж ажиллах; | - | Гэрээ байгуулсан спорт холбоодын тоо | 2023 онд биеийн тамир спортын 26 төрийн бус байгууллагад дэмжлэг үзүүлж ажилласан. | 2024 онд биеийн тамир спортын 26 төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж дэмжлэг үзүүлж, чадавхжуулж ажиллана. | Тайлант оны эхний хагас жилд биеийн тамир, спортын 26 төрийн бус байгууллагатай 127 уралдаан тэмцээнийг хамтран зохион байгуулж, улсын төсвөөс 49,8 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 348,8 сая төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлж ажилласан. | ~~70%~~ 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.5 | Арга хэмжээ-5: Сумдад ажиллах биеийн тамирын арга зүйчийн тоог нэмэгдүүлэх; | Орон нутгийн төсөв 12,0 сая төгрөг | Арга зүйчийн тоо | Баян-Өндөр суманд 1 арга зүйч ажилласан. | Сумдад ажиллах арга зүйчийн тоог 1-ээр нэмэгдүүлж, Жаргалант суманд биеийн тамирын арга зүйч ажиллуулна. | Баян-Өндөр суманд орон тооны 1 арга зүйч ажиллаж байна.Жаргалант суманд орон тооны арга зүйч байхгүй, арга зүйчийг сумын ЗДТГ-ын Боловсрол, соёл, спортын асуудал хариуцсан мэргэжилтэн давхар хариуцан ажиллаж байна. | 50% ✓ |
| 1.6 | Арга хэмжээ-6: Биеийн тамир, спортын улсын хорооноос зохион байгуулах мэргэшүүлэх сургалтад биеийн тамирын арга зүйч нарыг хамруулах; | Улсын төсөв 3,0 сая төгрөг | Сургалтад хамруулсан арга зүйчийн тоо | Биеийн тамир, спортын улсын хорооноос зохион байгуулсан 6 удаагийн сургалтад давхардсан тоогоор 31 арга зүйч, албан хаагчид мэргэшүүлэх, туршлага судлах сургалт, зөвлөгөөнд хамрагдсан. | Биеийн тамир, спортын улсын хорооноос зохион байгуулах сургалтад 2 арга зүйчийг гадаад улсад сургалтад хамруулна. | Биеийн тамир, спортын улсын хорооноос "Биеийн тамирын арга зүйч нарын мэргэжил дээшлүүлэх" сургалтыг БНХАУ-ын Бээжин хотод 04 дүгээр сарын 19-ний өдрөөс 24-ний өдрүүдэд зохион байгуулж, тус сургалтад Биеийн тамир, спортын газраас 1 мэргэжилтэн хамрагдсан. | 50% / 90 |
| 1.7 | Арга хэмжээ-7: Иргэдэд эерэг нөлөөлөл үзүүлэх нийтийн биеийн тамирын сайн дурын идэвхтнийг тогтмол хүртээмжтэй ажиллуулах; | Орон нутгийн төсөв 1,5 сая төгрөг | Сайн дурын идэвхтний тоо | 2023 онд нийтийн биеийн тамирын сайн дурын 3 идэвхтэн ажиллуулсан. | 2024 онд нийтийн биеийн тамирын сайн дурын идэвхтэнг 3-аар нэмэгдүүлж, 6 иргэн ажиллуулна. | Тайлант оны эхний хагас жилд "Хичээллэе-Өрнүүлье-Хэвшье" аяны хүрээнд "Эртэч-Эрдэнэтчүүд" өглөөний дасгалын арга хэмжээний хүрээнд аймгийн хэмжээнд дасгал хөдөлгөөнийг 3 байршилд зохион байгуулсан. Дасгалыг сайн дурын 4 идэвхтэй багш батлагдсан хуваарийн дагуу 7 хоногт 3 өдөр иргэдийг оролцуулан хийж байна. | 70% / 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.8 | Арга хэмжээ-8: Орон сууцны болон гэр хорооллын дундах спорт, чөлөөт цагийн талбайн ашиглалтыг сайжруулж биеийн тамир спортын уралдаан тэмцээнийг нэмэгдүүлнэ. | - | Ашиглалтыг сайжруулсан талбайн тоо | Гадна талбайд биеийн тамир, спортын арга хэмжээг 9 удаа зохион байгуулж, 1460 иргэнийг хамруулсан. | Гадна талбайд биеийн тамир, спортын арга хэмжээг 10 удаа зохион байгуулж, 1560 иргэнийг хамруулна. | Аймгийн хэмжээнд орон сууцны болон гэр хорооллын байршилд амралт, чөлөөт цагийн 122 талбайд иргэд, хүүхэд, залуус чөлөөт цагаа зөв зохистой өнгөрүүлж биеийн тамир, спортоор хичээллэж байна.<br>Тайлант онд чөлөөт цагийн 5 талбайд идэвхтэй дасгал хөдөлгөөнд 2800 иргэн, спортын 8 удаагийн тэмцээнд 1560 иргэн, нийт 4360 иргэнийг хамруулсан. Үүнд:<br>-"Хичээллэе-Өрнүүлье-Хэвшье" аяны хүрээнд "Эртэч-Эрдэнэтчүүд" Өглөөний дасгалын арга хэмжээг 3 байршилд зохион явуулж 2800 иргэн;<br>-Гэр бүлийн сарын аян, Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр, Автомашингүй өдөр зэрэг арга хэмжээний хүрээнд Амар агсаны нэрэмжит төв талбай, Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэн, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-н спорт цогцолборын дэргэдэх хөл бөмбөгийн гадна талбай, Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн талбайд хөгжөөнт буухиа, 3х3 сагсан бөмбөг, хөлбөмбөг, олс таталт зэрэг тэмцээн уралдааныг зохион явуулж 3570 иргэнийг тус тус хамрууллаа. | 90% / 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Стратеги төлөвлөгөөний зорилт-2. Биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй нэг хэсэг болгож, идэвхтэй амьдралын хэвшилтэй иргэн, гэр бүлийг дэмжих, мэргэжлийн спорт баг тамирчдын амжилтыг нэмэгдүүлнэ. | | Улсын төсөв 10,3 сая төгрөг, Орон нутгийн төсөв 42,2 сая төгрөг | Иргэдэд эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлж, хэвшүүлэн нийтийн дасгал хөдөлгөөнийг иргэдийн дунд өрнүүлсэн байна. | Биеийн тамир чийрэгжилтийн 160 арга хэмжээг зохион байгуулж, 40013 иргэнийг хамруулсан. | Биеийн тамир чийрэгжилтийн арга хэмжээг 165 удаа зохион байгуулж 40621 иргэнийг хамруулна. | Тайлант оны эхний хагас жилд биеийн тамир, чийрэгжилтийн 79 удаагийн арга хэмжээнд давхардсан тоогоор 32,450 иргэдийг хамруулсан. | 60% 95 |
| 2.1 | Арга хэмжээ-1: Фитнес клубт хичээллэгсдийн тоог нэмэгдүүлэх; | - | Хичээллэсэн иргэдийн тоо | 2023 онд 14 фитнес клубт хичээллэгсдийн тоог 100-аар нэмэгдүүлж, 1900 иргэн тогтмол хичээллэсэн. | 2024 онд фитнес клубын тоог 1-ээр нэмэгдүүлж, 15 фитнес клубт хичээллэх иргэдийн тоог 2000-д хүргэнэ. | Тайлант оны эхний хагас жилд фитнес клуб 1-ээр, хичээллэгсдийн тоог өмнөх оноос 100-аар нэмэгдүүлж, аймгийн хэмжээнд 15 фитнесс клубт 2000 иргэн тогтмол хичээллэж байна. | 100% ✓ |
| 2.2 | Арга хэмжээ-2: Шинээр хөгжиж буй спортын төрлийг орон нутгийн түвшинд хамрах хүрээг тэлж, хүн амд үзүүлэх биеийн тамир, спортын ажил үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх; | Орон нутгийн төсөв 2,0 сая төгрөг | Шинээр хөгжүүлсэн спортын төрлийн тоо | 2023 онд шинээр хөгжиж байгаа спортын 5 төрлөөр 7 удаа тэмцээн зохион байгуулж 400 иргэн хамруулсан. | Шинээр хөгжиж байгаа спортын төрлийг 2-оор нэмэгдүүлж, 7 төрлөөр уралдаан тэмцээн зохион байгуулж 450 иргэнийг хамруулна. | Тайлант оны эхний хагас жилд шинээр хөгжиж байгаа софт волейбол, граунд гольф, бочи, корн-holl, мас-рестлинг, гар дээр суниалтын спортын 6 төрлөөр 380 тамирчин биеийн тамир, спортын газрын А, Б заал, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-н спорт цогцолборын заалнуудад 7 хоногт 6 өдөр 2 цагаар тогтмол хичээллэж байна. Үүнд:<br>• софт волейболын спортоор 120 тамирчин;<br>• граунд гольфийн төрлөөр 130 тамирчин; | 70% ✓ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.3 | | | | | | • бочи спортын төрлөөр хөгжлийн бэрхшээлтэй 15 тамирчин;<br>• корн-holl спортын төрлөөр 45 тамирчин;<br>• мас-рестинг буюу модон барилдааны төрлөөр 40 тамирчин;<br>• гар дээр суниалтын спортын төрлөөр 30 тамирчин. | |
| 2.3 | Арга хэмжээ-3:<br>Спортын хэрэгслийн /ердийн болон цахилгаан дугуй, цана, тэшүүр, дугуйт цана, дугуйт тэшүүр/ түрээсийн үйлчилгээг нэвтрүүлэх санал санаачилгыг дэмжих; | Аж ахуйн нэгж, байгууллагын зардлаар | Түрээсийн үйлчилгээ үзүүлсэн аж ахуйн нэгжийн тоо | 2023 онд 6 иргэн аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж, 7200 иргэн түрээсийн үйлчилгээнд хамрагдсан. | 6 иргэн аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж, хичээллэх иргэдийн тоог 100-аар нэмэгдүүлж, 7300-д хүргэнэ. | Тайлант онд 3 байршилд 3 иргэн, аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж, уулын цана, чарга, тэшүүрийн түрээсийн үйлчилгээг 3050 гаруй хүүхэд залууст хүргэж ажиллалаа. Үүнд:<br>-"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Сархиа цанын баазад чарга, уулын цана, тэшүүрийн түрээсийн үйлчилгээнд 2200 иргэн;<br>- 19-р сургууль /орос сургууль/ дахь мөсөн талбайн тэшүүрийн түрээсийн үйлчилгээнд 1200 иргэн;<br>-Эрдэнэт спорт амралтын хүрээлэнд тэшүүрийн түрээсийн үйлчилгээнд 650 иргэн тус тус үйлчлүүлсэн. | 40%<br>/100 |
| 2.4 | | | | | | Тайлант оны эхний хагас жилд 610 ахмад настнуудыг дасгал хөдөлгөөн, бэлтгэл сургуулилт | 50%<br>100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Арга хэмжээ-4:<br>Ахмад настнуудыг спортоор хичээллэх, дасгал хөдөлгөөнд хамруулах нөхцөл боломжоог бүрдүүлж спортын заал танхимаар хангах; | Орон нутгийн төсөв 5,0 сая төгрөг | Хамрагдсан иргэдийн тоо | 2023 онд спорт заал 5, чийрэгжүүлэх танхим 9 нийт 472 ахмад настан дасгал хөдөлгөөн спортоор хичээллэсэн. | 2024 онд 490 ахмад настныг дасгал хөдөлгөөн, бэлтгэл сургуулилт хийх спортын заал, танхимаар хангана. | хийхэд спортын заал, танхимаар ханган ажилласан.<br>Аймгийн ахмадууд софт волейбол, шатар, хөлбөмбөг, сагсан бөмбөг волейбол, граунд гольф, дартс, ширээний теннис, бадминтон, хөнгөн атлетикийн төрлүүдээр Биеийн тамир спортын газрын А, Б заал, Баян-Өндөр сумын спорт заал, аймгийн ЗДТГ-ын спорт заал, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Спорт цогцолборын заалуудад үнэ төлбөргүй 7 хоногт 2 цагаар хичээллэж байна.<br>Мөн өрхийн эрүүл мэндийн төвүүд, аймгийн ахмадын хорооны чийрэгжүүлэлтийн танхимд хийн дасгалаар тогтмол 472 ахмад хичээллэдэг. | |
| 2.5 | Арга хэмжээ-5:<br>"Ахмадын эрүүл мэндийг дэмжих" сарын аян болон ахмадуудын дунд спортын 10 төрлөөр тэмцээн уралдаан зохион байгуулах; | Улсын төсөв 3,0 сая төгрөг | Тэмцээний тоо | Спортын 10 төрөлд 15 удаагийн арга хэмжээг зохион байгуулж 1089 ахмад настныг хамруулсан. | Спортын 10 төрөлд 16 удаагийн арга хэмжээг зохион байгуулж 1200 ахмад настныг хамруулна. | Ахмадуудын дунд спортын 7 төрлөөр тэмцээн зохион байгуулж, 594 тамирчдыг хамруулсан.Үүнд:<br>-Софт волейболын холимог багийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнд 96 тамирчин;<br>-Софт волейболын эрэгтэй , эмэгтэй багуудын аварга шалгаруулах тэмцээнд 18 багийн 70 тамирчин;<br>-Софт волейболын аймгийн аварга шалгаруулах тэмцээнд 18 багийн 108 ахмад, | 50% / 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -Бадминтоны ахмадын аймгийн аварга шалгаруулах тэмцээнд 60 тамирчин;<br>-Ширээний теннисний ахмадын олон хотын тэмцээнд 150 тамирчин;<br>-Хөл бөмбөгийн тэмцээнд 80 тамирчин;<br>-Граунд гольфийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнд 30 ахмад тамирчин тус тус хамрагдлаа. | |
| 2.6 | Арга хэмжээ-6:<br>Ахмад мастеруудын спортын VIII наадамд баг тамирчдыг оролцуулж амжилтыг нэмэгдүүлэх; | Улсын төсөв 1,5 сая төгрөг | Тамирчдын тоо | 2023 онд Ахмад мастеруудын спортын VII наадамд Орхон аймгаас спортын 8 төрөлд 80 тамирчныг оролцуулсан. | 8 төрөлд 80 тамирчин оролцуулж, амжилтыг нэмэгдүүлнэ. | Ахмад мастеруудын спортын VIII дугаар наадам 2024 оны 07 дугаар сарын 03-07-ны өдрүүдэд Архангай аймгийн Цэцэрлэг хотод спортын 8 төрлөөр зохион байгуулагдана.Тус тэмцээнд Орхон аймгаас спортын 8 төрлөөр 80 тамирчин оролцохоор 06 дугаар сарын 03-ны өдрөөс бэлтгэл сургуулилтаа хийж байна. | 30%<br>/<br>70 |
| 2.7 | Арга хэмжээ-7:<br>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг спортоор хичээллэх орчин нөхцлийг бүрдүүлж спортын заал танхимаар хангаж хичээллэгсдийн тоог нэмэгдүүлэх; | - | Хичээллэсэн иргэдийн тоо | 2023 онд спортын 2 зааланд спортын 9 төрлөөр 350 иргэн тогтмол хичээллэсэн. | А, Б зааланд спортын 9 төрлөөр 360 иргэн тогтмол хичээллэх заал танхимаар хангана. | Хөгжлийн бэрхшээлтэй тамирчдыг байгууллагын А, Б зааланд спортын 9 төрлөөр /3х3 сагсан бөмбөг, буухиа, дартс, ширээний дуут бөмбөг, волейбол, хонхот бөмбөг, суугаа волейбол, бочи/ 365 иргэн тогтмол хичээллэсэн. | 50%<br>/<br>100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.8 | Арга хэмжээ-8: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах; | Орон нутгийн төсвөөс 2,0 сая төгрөг | Зохион байгуулсан тэмцээн, өдөрлөгийн тоо | Биеийн тамир, спортын арга хэмжээг 9 төрлөөр 11 удаа тэмцээн зохион байгуулж давхардсан тоогоор 370 иргэнийг хамруулсан. | Биеийн тамир, спортын арга хэмжээг 9 төрлөөр 12 удаа тэмцээн зохион байгуулж давхардсан тоогоор 450 иргэнийг хамруулна. | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд аймгийн аварга шалгаруулах тэмцээн /хонхтой бөмбөгийн пара волейбол, сагсан бөмбөг/-ийг зохион байгуулж, 120 тамирчин оролцсон. Монголын тусгай Олимпийн хорооноос зохион байгуулсан гүйлтийн цаны тэмцээнд Орхон аймгаас 3 тамирчин оролцож, тамирчин С.Идэр түрүүлэн 2025 онд Итали улсад болох Олимпийн эрхийг авсан. Мөн тус хороотой хамтран "Залуу манлайлал" сургалтыг зохион байгуулж, аймгийн тусгай хэрэгцээт 22 хүүхэд оролцсон. | 30% 100 |
| 2.9 | Арга хэмжээ-9: Суугаа волейболын улсын аварга шалгаруулах тэмцээнд баг тамирчдыг оролцуулах; | Улсын төсөв 800,0 мянган төгрөг | Тамирчдын тоо | 2023 онд Суугаа волейболын улсын аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцож хүрэл медаль хүртсэн. | Улсын аварга шалгаруулах тэмцээнд 8 тамирчин оролцуулж, амжилтыг нэмэгдүүлнэ. | Суугаа волейболын улсын аварга шалгаруулах тэмцээн 2024 оны 08 дугаар сард Архангай аймгийн Цэцэрлэг хотод зохион байгуулагдана.Тус тэмцээнд аймгийн аварга шалгаруулах тэмцээнээс шалгарсан эрэгтэй 1, эмэгтэй 1 багийн 16 тамирчин, 1 дасгалжуулагч оролцохоор бэлтгэл сургуулилтаа хийж байна. | 30% 70 |
| 2.10 | Арга хэмжээ-10: Хийн болон эрүүл мэндийн дасгал хөдөлгөөнийг сурталчилж | | Дасгал хөдөлгөөнд хамрагдсан иргэдийн тоо | 2023 онд "Хичээллэе-Өрнүүлье-Хэвшье" аяны хүрээнд Өглөөний дасгал | "Хичээллэе-Өрнүүлье-Хэвшье" аяныг зохион байгуулж | Тайлант оны эхний хагас жилд "Хичээллэе-Өрнүүлье-Хэвшье" аяны хүрээнд 4 удаагийн арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор 24,044 | 100% ✓ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | "Хичээллэе-Өрнүүлье-Хэвшье" аяныг аймгийн иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудын дунд өрнүүлэх | Орон нутгийн төсөв 3,0 сая төгрөг | | 18231 иргэн хамруулсан. | 18300 иргэнийг хамруулна. | мянган иргэнийг хамруулсан. Тус арга хэмжээнд орон нутгийн төсвөөс 8,0 сая төгрөг зарцуулсан.Үүнд:<br>-"Ажлын байрны дасгал"-ын цахим дасгалын уралдаанд 47 байгууллагын давхардсан тоогоор 21,184 ажилтан албан хаагч;<br>-"Эртэч Эрдэнэтчүүд" Өглөөний дасгалын арга хэмжээнд давхардсан тоогоор 2400 иргэн;<br>-Төрийн албан хаагчдын дунд "Цасны баяр"-ын арга хэмжээнд 23 байгууллагын 400 гаруй албан хаагч;<br>-Жаргалант сумын аж ахуйн нэгж, төрийн байгууллага, иргэдийн дунд "Биеийн тамирын өдөрлөг"-ийн арга хэмжээнд 6 багийн 60 тамирчин; | |
| 2.11 | Арга хэмжээ-11:<br>"Хичээллэе-Өрнүүлье-Хэвшье" аяны хүрээнд Төрийн албан хаагчдын дунд "Цасны баяр" арга хэмжээг багийн болон үндэсний спортын 4 төрлөөр тэмцээн зохион байгуулна. | Орон нутгийн төсөв 2,0 сая төгрөг | Тэмцээний тоо | - | Багийн болон үндэсний спортын 4 төрлөөр тэмцээн зохион байгуулна. | "Хичээллэе-Өрнүүлье-Хэвшье" аяны хүрээнд Төрийн албан хаагчдын дунд "Цасны баяр-2024" өдөрлөгийг "Эрдэнэт спорт амралтын хүрээлэн"-гийн мөсөн талбайд 2024 оны 01 сарын 27-ний өдөр амжилттай зохион байгуулсан. Тус өдөрлөгт төрийн болон төрийн өмчит 23 байгууллагын 400 гаруй албан хаагч спортын 4 төрөл /гүйлтийн тэшүүр олс таталт буухиа мөсний шагай/- | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өөр хурд, хүчээ сорин өрсөлдсөнөөс:<br>Багийн нэгдсэн дүнгээр:<br>1-р байр Хурандаа Г.Ганбаатар даргатай Онцгой байдлын газар,<br>2-р байр Б.Гантулга захиралтай Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ-ТӨХК;<br>3-р байр П.Баясгалан даргатай Хот байгуулалт, барилга захиалагчийн алба;<br>4-р байр Х.Эрдэнэбат даргатай Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар;<br>5-р байр Х.Хишигбаатар даргатай Хүүхэд, залуучуудын театрын баг тамирчид тус тус шалгарч, өргөмжлөл мөнгөн шагналын эзэд болсон.<br>Тус арга хэмжээг аймгийн Засаг даргын Тамгын газар, Соёл урлагийн газар болон харьяа соёлын төвүүд, "Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэн", "Тэшүүрийн холбоо" ТББ, "Мөнгөн толь" мөсөн шагайн холбоо ТББ-уудтай хамтран зохион байгуулсан. | |
| 2.12 | Арга хэмжээ-12:<br>“Авто машингүй нэг өдөр” арга хэмжээ зохион байгуулна. | Орон нутгийн төсөв 1,0 сая төгрөг | Хамрагдсан иргэдийн тоо | 2023 онд “Авто машингүй нэг өдөр” арга хэмжээг 3 удаа зохион байгуулж, уралдаан тэмцээнд 1640 | “Авто машингүй нэг өдөр” арга хэмжээний хүрээнд тэмцээн уралдаан зохион байгуулж, 1700 | Тайлант оны эхний хагас жилд “Авто машингүй нэг өдөр” арга хэмжээг Монгол Улсын Ерөнхий сайд асан А.Амарын нэрэмжит төв талбайд зохион байгуулж, 1030 хүүхдийг оролцуулсан. Үүнд: | 60%<br>100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | иргэнийг хамруулсан. | иргэнийг хамруулна. | •Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр буюу 2024 оны 06 дугаар сарын 01-ний өдрийг "Автомашингүй нэг өдөр" болгон "Хүрэнбулаг" ХХК урдаас Монгол Улсын ерөнхий сайд асан А.Амарын нэрэмжит төв талбай хүртэл авто замын хөдөлгөөнийг түр хааж зохион байгуулсан.Хүүхдийн баярын нээлтэд спортын 4 төрлөөр үзүүлэх тоглолт, сагсан бөмбөг, унадаг дугуйн тэмцээнийг зохион байгуулж нийт 1030 хүүхдийг хамруулсан. Үүнд: үзүүлэх тоглолтод 80 өсвөрийн тамирчид, сагсан бөмбөгийн 3х3 тэмцээнийг U17-U18 насны ангилалд 22 багийн 88 хүүхэд, "Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэн"-д сагсан бөмбөгийн 3х3 тэмцээнийг U13-U14, U15-U16 насны ангиллаар зохион байгуулж 134 багийн 536 хүүхэд, мөн сагсан бөмбөгийн "Алтан цаг" клубын уралдаанд 152 хүүхэд, үндэсний бөхийн барилдааныг 4 насны ангиллаар зохион байгуулж 64 өсвөрийн бөхчүүд, унадаг дугуйн тэмцээнийг 3 насны ангиллаар зохион байгуулж 110 хүүхдийг тус тус хамруулсан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.13 | Арга хэмжээ - 13: Аймгийн хэмжээнд Иргэдийн спортын наадмыг зохион байгуулах; | Орон нутгийн төсөв 23,0 сая төгрөг | Зохион байгуулсан спортын төрлийн тоо | Иргэдийн спортын наадмыг Баян-Өндөр, Жаргалант сумын 26 багийн иргэдийн дунд багийн болон үндэсний спортын 8 төрлөөр зохион байгуулж 1163 иргэн хамруулсан. | Иргэдийн спортын наадмыг Баян-Өндөр, Жаргалант сумын 29 багийн иргэдийн дунд багийн болон үндэсний спортын 8 төрлөөр зохион байгуулна. | Тайлант оны 10 сард зохион байгуулахаар төлөвлөсөн. Тайлбар: жил бүрийн 10-11 сард зохион байгуулж байсан. | - ХБ |
| 2.14 | Арга хэмжээ - 14: Явган алхалтын аймгийн аварга шалгаруулах тэмцээн болон алхалтын бусад арга хэмжээг зохион байгуулах; | Улсын төсөв 2,0 сая төгрөг | Хамрагдсан иргэдийн тоо | 2023 онд явган алхалтын арга хэмжээг 4 удаа зохион байгуулж 400 иргэнийг хамруулсан. | Явган алхалтын арга хэмжээг 4 удаа зохион байгуулж, 420 иргэнийг хамруулна. | Тэмцээнийг 05 дугаар сарын 17-18-ны өдрүүдэд зохион байгуулахаар байгууллагын сарын төлөвлөгөөнд тусгасан боловч энэ хугацаанд Биеийн тамир, спортын салбар үүсч хөгжсөний 100 жилийн ойн арга хэмжээ давхцаж тэмцээнийг хойшлуулж 10 дугаар сард зохион байгуулахаар төлөвлөсөн. | 30% / 50 |
| 2.15 | Арга хэмжээ-15: Гэр бүлийн сарын аяны хүрээнд биеийн тамир, спортын 4 төрлөөр арга хэмжээ зохион байгуулах; | Орон нутгийн төсөв 750.0 мянган төгрөг | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 2023 онд биеийн тамир, спортын 4 төрлөөр арга хэмжээ зохион байгуулж, 300 хүүхдийг хамруулсан. | Биеийн тамир, спортын 4 төрлөөр арга хэмжээ зохион байгуулж, 350 хүүхдийг хамруулна. | Гэр бүлийн сарын аяны хүрээнд “Бүх хайраа гэр бүл”-дээ өдөрлөгийн хүрээнд Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнд U12 насны эрэгтэй, эмэгтэй тамирчдын дунд 3х3 сагсан бөмбөгийн тэмцээнийг зохион байгуулж эрэгтэй 36, эмэгтэй 16 багийн 200 тамирчин оролцсон. | 60% / 100 |
| 2.16 | Арга хэмжээ-16: “Гимнастрада-2024” бүх нийтийн | Арга хэмжээ-16: | Орон нутгийн төсөв 1.5 сая төгрөг | Арга хэмжээнд хамрагдсан хүүхдийн тоо | 2023 онд 2 үе шаттай зохион байгуулж, | “Гимнастрада-2024” арга хэмжээг 2 үе шаттай зохион | 100% ✓ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| гимнастикийн арга хэмжээг зохион байгуулах; | "Гимнастрада-2024" бүх нийтийн гимнастикийн арга хэмжээг зохион байгуулах; | | | давхардсан тоогоор 1800 хүүхдийг хамруулсан.<br>1850 хүүхдийг хамруулна 100 | байгуулж, нийт 2750 хүүхдийг хамруулсан.<br>-Анхан шатны тэмцээнийг сургуулийн өмнөх боловсролын 18 байгууллагын хүүхэд багачуудын дунд зохион явуулж, 2450 хүүхэд оролцсон.<br>-Монгол Улсад орчин цагийн Биеийн тамир, спортын салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ой "Хичээллэе-Өрнүүлье-Хэвшье" аяны хүрээнд Орхон аймгийн "Гимнастрада-2024" аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-н Спорт цогцолборт 05 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулж, тэмцээнд 10 цэцэрлэгийн 300 хүүхэд оролцож аваргаа шалгаруулсан. | |
| Стратеги төлөвлөгөөний зорилт-3: Монгол үндэсний уламжлалт спортыг орон нутагтаа хөгжүүлэх, сурталчлах, зохион байгуулах | Орон нутгийн төсөв 14,0 сая төгрөг | Үндэсний спортын төрлийн тоо, хамрагдсан иргэдийн тоо | Үндэсний спортын 5 холбоотой хамтран 5 удаа тэмцээн зохион байгуулсан. | Үндэсний спортын 6 холбоотой хамтран спортын 6 төрлөөр арга хэмжээ зохион явуулж 2000 иргэнийг хамруулах | Тайлант оны эхний хагас жилд үндэсний спортын 4 төрлөөр 12 удаагийн тэмцээн уралдааныг зохион байгуулж, 1694 тамирчдыг хамруулсан.<br>Үүнд:<br>-Мөсний шагай аймгийн аварга шалгаруулах тэмцээнд 8 багийн 64 тамирчин;<br>-Баян-Өндөр сумын 30 жилийн ойн хүрээнд сумын аварга шалгаруулах мөсний шагайн тэмцээнд 24 багийн 192 тамирчин; | 60% / 98.5 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -мөсний сурын аймгийн аварга шалгаруулах тэмцээнд 11 багийн 88 тамирчин;<br>-шагайн харвааны аймгийн аварга шалгаруулах тэмцээнд 14 багийн 112 тамирчин;<br>бусад нэрэмжит 4 удаагийн тэмцээнд 424 тамирчин;<br>-үндэсний бөхийн өсвөр, залуучууд, насанд хүрэгчдийн төрлөөр 12 удаагийн барилдаанд 814 тамирчин тус тус оролцсон.<br>Арга хэмжээнүүдийг тухай бүр аймгийн хэвлэл мэдээлэл болон телевизээр иргэдэд сурталчилсан. | |
| 3.1 | Арга хэмжээ-1:<br>Үндэсний спортоор хичээллэгчдийн тоог нэмэгдүүлэх; | - | Хичээллэгчдийн тоо | Үндэсний спортын 5 төрлөөр 930 тамирчин хичээллэсэн. | Үндэсний спортын 5 төрлөөр хичээлэгчдийн тоог 130-аар нэмэгдүүлж, 1060-д хүргэнэ. | Тайлант оны эхний хагас жилд үндэсний спортоор хичээллэгчдийн тоог 60-аар нэмэгдүүлж, үндэсний спортын 5 төрлөөр 990 тамирчин бэлтгэл сургуулилтаа хийж байна. | 50%<br>92,3 |
| 3.2 | Арга хэмжээ-2:<br>Үндэсний спортыг өсвөр үе, хүүхэд багачуудад сурталчлан таниулах, өвлөн уламжлуулах зорилгоор "Цоллооч хүүхэд шалгаруулах уралдаан"-ыг зохион байгуулах; | Орон нутгийн төсөв-1,5 сая төгрөг | Уралдаанд хамрагдсан хүүхдийн тоо | 2023 онд "Цоллооч хүүхэд шалгаруулах уралдаан"-ыг зохион байгуулж, 60 хүүхдийг хамруулсан. | Уралдааныг 2 үе шаттай зохион байгуулж, 80 хүүхдийг хамруулна. | Хугацаа болоогүй. | -<br>ХБ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.3 | Арга хэмжээ-3: Үндэсний баяр наадмыг спортын 4 төрлөөр зохион байгуулах; | Орон нутгийн төсөв-батлагдсан төсвийн хүрээнд | Зохион байгуулсан тэмцээний тоо | Үндэсний баяр наадмаар спортын 4 төрлөөр уралдаан тэмцээн зохиогдсон. | Үндэсний баяр наадмаар спортын 4 төрлөөр уралдаан тэмцээн зохион байгуулна. | Хугацаа болоогүй. Тайлбар: 08 дугаар сарын 01,02-ны өдрүүдэд зохион байгуулагдана. | - ХБ |
| 3.4 | Арга хэмжээ-4: Үндэсний бөхийн барилдааныг өсвөр үе, залуучууд, насанд хүрэгчдийн насны ангиллаар зохион байгуулж, тамирчдын амжилтыг нэмэгдүүлэх; | Улс, орон нутгийн төсөв, аж ахуйн нэгж байгууллагын зардал, хандив тусламжийн хөрөнгөөр | Зохион байгуулсан тэмцээний тоо | 2023 онд үндэсний бөхийн барилдааныг 29 удаа зохион байгуулж 2008 бөхчүүдийг хамруулсан. | Үндэсний бөхийн барилдааныг 3 насны ангиллаар 29 удаа зохион байгуулж, 2200 бөхчүүдийг хамруулна. | Тайлант оны эхний хагас жилд үндэсний бөхийн өсвөр үе, залуучууд, насанд хүрэгч 3 насны ангилалаар нийт 12 удаагийн барилдааныг зохион байгуулж, 814 тамирчиныг хамруулсан. | 40% / 100 |
| 3.5 | Арга хэмжээ-5: Шагайн харваа, мөсөн шагайн харвааны тэмцээнийг аймагтаа зохион байгуулж улс, бүсийн тэмцээнд дэмжлэг үзүүлж, тамирчдын амжилтыг нэмэгдүүлэх; | Улсын төсөв-2,0 сая төгрөг | Зохион байгуулсан тэмцээний тоо | 2023 онд шагайн харвааны тэмцээн 6, мөсний шагайн харвааны тэмцээн 6 удаа тус тус зохион байгуулж давхардсан тоогоор 700 гаруй тамирчныг оролцуулсан. | Шагайн харваа, мөсний шагайн харвааны нийт 13 тэмцээнийг зохион байгуулж оролцох тамирчдын тоог 750-д хүргэнэ. | Тайлант оны эхний хагас жилд шагай, мөсний шагайн харвааны спортын төрлөөр 12 удаагийн тэмцээн уралдааныг зохион байгууулж, 1694 иргэнийг хамруулсан байна. Үүнд: -Мөсний шагай аймгийн аварга шалгаруулах тэмцээнд 8 багийн 64 тамирчин; -Баян-Өндөр сумын 30 жилийн ойн хүрээнд сумын аварга шалгаруулах мөсний шагайн тэмцээнд 24 багийн 192 тамирчин, -Шагайн харвааны аймгийн аварга шалгаруулах тэмцээнд 14 багийн 112 тамирчин оролцож, улсын аварга | 90% / 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шалгаруулах тэмцээнд 10 тамирчин<br>-Бусад нэрэмжит 4 удаагийн тэмцээнд 424 тамирчин хамрагдсан. | |
| 3.6 | Арга хэмжээ-6:<br>Үндэсний сур харваа, мөсний сур харвааны тэмцээнийг зохион байгуулж, тамирчдын амжилтыг нэмэгдүүлэх; | Улсын төсөв-2,0 сая төгрөг | Зохион байгуулсан тэмцээний тоо | Үндэсний сур харваа, мөсний сур харвааны аймгийн аварга шалгаруулах болон нэрэмжит тэмцээнийг 6 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 260 тамирчин оролцсон. | Аймгийн аварга шалгаруулах болон нэрэмжит тэмцээнийг 7 удаа зохион байгуулж, оролцох тамирчдын тоог 270-д хүргэнэ. | Тайлант оны эхний хагас жилд мөсний сур харвааны тэмцээнийг 3 удаа зохион байгуулж, 204 тамирчин хамрагдсан. Мөсний сурын аймгийн аварга шалгаруулах тэмцээнд 1 тамирчин улсын мэргэний болзол хангасан байна.<br>-Үндэсний сур харвааны нээлттэй тэмцээн 05 дугаар сард "Эрдэнэт спорт амралтын хүрээлэн"-ийн сурын талбайд зохиогдон нийт 120 гаруй харваач цэц мэргэнээ сорьж оролцсон. | 70% / 100 |
| 3.7 | Арга хэмжээ-7:<br>Үндэсний уламжлалт спортын холбоодод дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах; | Улсын төсөв 4,0 сая төгрөг | Хамтран ажилласан спорт холбоодын тоо | 2023 онд үндэсний спортын 5 холбоотой хамтран ажиллах гэрээ байгуулж дэмжлэг үзүүлэн ажилласан. | Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг үндэсний спортын 5 холбоотой хамтран ажиллах гэрээ байгуулж, дэмжлэг үзүүлэн ажиллана. | Тайлант оны эхний хагас жилд үндэсний спортын 4 төрлөөр 12 удаагийн тэмцээн уралдааныг зохион байгууулж, 1694 иргэнийг хамруулсан. Үүнд: Шагайн харвааны Цэц мэргэн холбоо, мөсний сурын Мөнгөн толь холбоо, үндэсний бөхийн холбоо, мөсний сурын холбоодуудад тэмцээн уралдааныг зохион байгуулахад орон нутгийн болон улсын төсвөөс 8,470,000 төгрөгний | 50% / 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | санхүүгийн дэмжлэгийг үзүүлсэн. | |
| Стратеги төлөвлөгөөний зорилт-4: Спортын сургалт дасгалжуулалт, тэмцээн уралдааны шаталсан тогтолцоо зэрэглэлийг бий болгож, төр төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг бэхжүүлэн, хүний нөөцийг мэргэшүүлэх, тамирчдын бүс, улс, олон улс, тив, дэлхийд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, тамирчид, дасгалжуулагчдын сахилга хариуцлагыг сайжруулна. | | Улсын төсөв–20,0 сая төгрөг, Орон нутгийн төсөв 23,0 сая төгрөг | Сургалт дасгалжуулалтын чанарт ахиц гарч төрийн ба төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаа сайжирч, тамирчдын ур чадвар амжилт нэмэгдсэн байх | 2023 онд спортын 37 төрлөөр 420 удаагийн тэмцээн уралдаанд давхардсан тоогоор 51,450 иргэнийг хамруулсан. Орхон аймгийн тамирчид 2023 онд тив, дэлхий, олон улс, улсын аварга шалгаруулах тэмцээнээс 483 багц медаль авсан амжилтыг үзүүлсэн. | Спортын тэмцээн уралдааныг амжилттай зохион байгуулж, төрийн болон төрийн бус байгууллагуудын оролцоог нэмэгдүүлж, тамирчдын амжилт ахисан байна. | Тайлант оны эхний хагас жилд аймгийн хэмжээнд спортын 32 төрлөөр 270 удаагийн тэмцээн уралдаанд давхардсан тоогоор 29,800 иргэнийг хамруулсан. Орхон аймгийн тамирчид 2024 оны эхний 5 сард тив, дэлхий, олон улс, улсын аварга шалгаруулах тэмцээнээс 208 багц медаль авсан амжилтыг үзүүлсэн. | 70% ✓ |
| 4.1 | Арга хэмжээ-1: Аймгийн өсвөрийн шигшээ багийн залгамж халааг сайжруулах улс, бүс, олон улсын түвшинд өрсөлдөх Аймгийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн тамирчдын тоог нэмэгдүүлж, хэрэглэл материалаар хангах; | Орон нутгийн төсөв 28,0 сая төгрөг | Шигшээ багт хичээллэсэн тамирчдын тоо | Спортын 16 төрлөөр өсвөрийн шигшээ багуудад 182 тамирчин хичээллэсэн. | Өсвөрийн шигшээ багийн тамирчдын тоог 14-өөр нэмэгдүүлж, спортын 16 төрөлд 196 тамирчин хичээллүүлнэ. | Тайлант оны эхний хагас жилд өсвөрийн шигшээ 16 багийн 3 багт 8 тамирчин нэмэгдэж, 190 өсвөрийн тамирчин бэлтгэл сургуулилалт хийж байна.<br>Өсвөрийн шигшээ багийн төрөл, тамирчдын тоо: сагсан бөмбөг 3х3, 5х5 төрөлд 28 хүүхэд, байт харваа-5, гимнастик-8, цана-16, хөлбөмбөг-20, бадминтон-5, бокс-10, буудлага-8, таеквондо-12, ширээний теннис-4, самбо, жүдо-18, чөлөөт бөх-16, волейбол-20, шатар-4, хөнгөн атлетик-16 тамирчин тус тус хичээллэж байна. Өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах | 90%<br>85.7 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тэмцээнийг 13 төрлөөр зохион байгуулж, нийт 2152 өсвөрийн тамирчид хамруулж, орон нутгийн төсвөөс 22,0 сая төгрөг зарцуулсан.<br>Өсвөр үеийн улсын аварга шалгаруулах 15 тэмцээнд 927 тамирчныг оролцуулж 161 медаль, бүсийн аварга шалгаруулах тэмцээнээс 92 медаль тус тус авсан амжилтыг үзүүлсэн. Үүнээс улсын аварга шалгаруулах тэмцээнээс алт 57 мөнгө, 49 хүрэл, 55 нийт 161 медаль, бүсийн аварга шалгаруулах тэмцээнээс алт 25, мөнгө 23, хүрэл 44, нийт 92 медаль авсан амжилтыг үзүүлсэн. | |
